



## АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар (цаашид Журам гэх) АПУ ХК (цаашид Компани гэх)-ийн хөрөнгө оруулагчдад хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм, журмуудад нийцсэн байх ба Компанийн ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаа нь тэдгээрийг мөрдлөг болгоно.
- 1.3. Журам нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) баталснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

### ХОЁР. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

- 2.1. Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд хуваарилах бодлого баримтална.
- 2.2. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:
  - 2.2.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх,
  - 2.2.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх,
  - 2.2.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 2.3. Компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргаж, энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.
- 2.4. ТУЗ-өөс тухайн жилд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэр гаргавал энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах үүрэгтэй.
- 2.5. ТУЗ нь компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэрийг хагас жилийн санхүүгийн тайлан гарснаас хойш 30 хоногийн дотор гаргах ба 2.2.1-2.2.3-т заасан нөхцөл хангагдсан байна.
- 2.6. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

- 2.7. Ногдол ашиг төлөх хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байх ба холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зөвлөмжийг харгалзана.
- 2.8. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь төлөхөөс өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэдээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

### **ГУРАВ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ**

- 3.1. Ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг Гүйцэтгэх удирдлагаас санал болгож болно.

### **ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ**

- 4.1. ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгож Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй жагсаалтыг гаргуулна.
- 4.2. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуульд заасан нөхцөл, журамд заасан шаардлагыг биелүүлсэн байна.
- 4.3. ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлийг тусгана, үүнд:
  - 4.3.1. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ,
  - 4.3.2. Ногдол ашгийг төлөх хугацаа,
  - 4.3.3. Төлөх арга зам, хэлбэр (Компани өөрөө болон эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулах, эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар төлөх гэх мэт)
  - 4.3.4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдөр
  - 4.3.5. Бусад холбогдох асуудал
- 4.4. ТУЗ-өөс ногдол ашгийг төлөх өдрийг тогтооход компанийн батлагдсан бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.
- 4.5. Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашиг зарласан хэмжээ, хуваарилалтын талаар мэдээллийг оруулна.
- 4.6. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- 4.7. Ногдол ашиг төлсний дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх захирал боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.

- 4.8. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг төлж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө.

#### **ТАВ. ТАЙЛАГНАХ**

- 5.1. Ногдол ашгийн хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гарган, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.
- 5.2. Ногдол ашиг төлсний дараагийн санхүүгийн улиралд Компани энэ талаар Нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгах үүрэгтэй.

#### **ЗУРГАА. ХАРИУЦЛАГА**

- 6.1. Хууль тогтоомж, ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын дүрэм, журмыг зөрчвөл буруутай этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
- 6.2. Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал хариуцна.

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2013 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн  
13/28 тоот тогтоолын хавсралтаар батлав.*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн  
19/01 тоот тогтоолын хавсралтаар  
оруулсан нэмэлт өөрчлөлтийг тусгав.*

*Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын  
2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн  
20/07 тоот тогтоолын хавсралтаар  
оруулсан нэмэлт өөрчлөлтийг тусгав.*

---oOo---